

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цемент шохой ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/046/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас: 261885 Цахим хаяг: erdenetsogt.v@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Долгоржав Утас: 261740 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn Нийслэл-Аудит ХХК-ийн захирал: Т.Сугарсүрэн Утас: 70110095 Цахим хаяг: info@niislelaudit.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30.
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЦЕМЕНТ ШОХОЙ ХХК-ИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАТТУВШИН ТАНАА

2025.03.31 № 07/1341
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цемент шохой ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон зорилтот түвшний гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Цемент шохой ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Тухайлбал:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх дотоод аудиторт 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан хөдөлмөрийн гэрээгээр сард 7.0 сая төгрөгийн цалинг олгохоор тогтоож, нийт 56.7 сая төгрөг олгосон бөгөөд хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүрэг гүйцэтгэх байршилд ажиллаагүй, ажлын цагаа бүртгүүлээгүй, алсын зайнаас ажилласан байна. Удирдлагын буруу шийдвэрээр ажлаас халагдсан албан тушаалтанд шүүхийн шийдвэрийн дагуу 282.7 сая төгрөгийн олговор олгосныг буруутай этгээдээр нөхөн төлүүлээгүй;
- Жилийн эцэст 74.7 сая төгрөгийн авлага, 367.6 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, Төрийн албаны тухай хуулийн 50.1 дүгээр заалт Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоол, Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журмын 7.2, Барилга, хот байгуулалтын салбарын 2021-2022 оны хамтын хэлэлцээрийн 5.1, 2023-2025 оны хамтын хэлэлцээрийн 3.7 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэлтэй байсан нийт 5,428.8 сая төгрөгийн өмнөх онуудын алдаатай бүртгэлийг залруулсан болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 4 дугаар тогтоолоор 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэр гарсан боловч 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 8 дугаар тогтоолоор 11,255.2 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилсан нь өмнөх оны өртэй нийлээд ногдол ашгийн өр нийт 17,070.5 сая төгрөг байна.

Бусад асуудлын хэсэг

Цемент шохой ХХК нь 2024 онд үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлангаар 8 чиглэлээр 9 зорилтын хүрээнд 154 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 85.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	242,464,355.22	21,055,306.46
1.1.2	Дансны авлага	5,398,356,646.06	5,645,411,070.75
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	10,414,474.54	78,276,587.20
1.1.4	Бусад авлага	14,260,562,748.19	14,531,435,072.44
1.1.6	Бараа материал	46,090,845,370.70	52,122,259,447.01
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,706,896,400.51	3,249,138,191.76
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	61,568,620.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	546,192,946.00	546,192,946.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	69,255,732,941.22	76,255,337,241.62
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	227,028,328,601.35	221,664,067,013.52
1.2.2	Биет бус хөрөнгө	8,223,704,778.80	9,615,605,400.29
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	3,167,577,706.42	3,110,309,086.42
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	238,419,611,086.57	234,389,981,500.23
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	307,675,344,027.79	310,645,318,741.85
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	7,821,808,734.36	9,034,226,101.71
2.1.1.2	Цалингийн өглөг	72,815,486.00	0.00
2.1.1.3	Татварын өр	16,819,264,078.44	18,803,243,539.73
2.1.1.4	НДШ - ийн өглөг	1,222,764,163.95	2,402,225,396.68
2.1.1.6	Хүүгийн өглөг	16,372,618,946.34	16,372,618,946.34
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	5,815,347,850.00	17,070,537,725.54
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	4,632,613,605.35	1,982,260,398.91
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/	15,437,867.72	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	191,211,347.71	190,415,024.11
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	52,963,882,079.87	65,855,527,133.02
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	41,916,835,529.58	41,916,835,529.58
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	2,213,391,285.66	2,213,391,285.66
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	3,103,027,378.08	3,103,027,378.08
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	275,738,820,300.00	276,158,820,300.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	322,972,074,493.32	323,392,074,493.32
2.2	Өр төлбөрийн нийт дүн	375,935,956,573.19	389,247,601,626.34
2.3	Эздийн өмч	11,945,269,000.00	11,945,269,000.00
2.3.1	Өмч:-төрийн	11,945,269,000.00	11,945,269,000.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	420,000,000.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	41,284,046,790.95	47,284,714,835.75
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	5,428,771,474.66	0.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(127,338,699,811.01)	(137,832,266,720.24)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(68,260,612,545.40)	(78,602,282,884.49)

2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	307,675,344,027.79	310,645,318,741.85
-----	---------------------------------------	---------------------------	---------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	85,605,128,141.52	71,356,825,536.7
2	Борлуулалтын өртөг	59,551,532,450.57	60,510,196,418.8
3	Нийт ашиг(алдагдал)	26,053,595,690.95	10,846,629,117.91
4	Түрээсийн орлого	12,188,049.12	3,434,181.82
5	Хүүгийн орлого	78,288,133.44	8,993,021.00
8	Бусад орлого	572,756,819.16	944,204,526.01
9	Борлуулалт, маркетингийн зардал	3,454,404,948.76	2,940,933,195.99
10	Ерөнхий ба удирдлагын зардал	9,563,645,617.58	7,802,271,280.45
12	Бусад зардал	688,872,683.22	1,012,574,740.25
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(3,825,122.06)	(205,510.06)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	12,927,792,187.61	47,276,119.99
19	Орлогын татварын зардал	1,750,890,445.51	27,469,337.86
20	Татварын дараах ашиг (алдагдал)	11,176,901,742.10	19,806,782.13
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	11,176,901,742.10	19,806,782.13
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Орлогын нийт дүн	11,176,901,742.10	19,806,782.13
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	84,201,261,636.60	64,876,062,610.43
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	83,666,932,968.42	64,250,326,219.59
1.1.4	Буцаан авсан албан татвар	92,396,368.54	56,427,763.37
1.1.6	Бусад мөнгөн орлого	441,932,299.64	569,308,627.47
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	79,549,372,466.54	62,546,293,870.83
1.2.1	Ажиллагчдад төлсөн	20,937,485,156.83	18,696,528,870.19
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	4,953,792,287.27	4,065,327,093.35
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	23,775,226,535.39	13,247,764,802.69
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	9,729,157,048.14	10,808,078,562.13
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	16,119,981,976.11	10,450,704,204.67
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	1,271,996.91	894,087.95
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	3,280,542,380.60	3,936,874,607.76
1.2.9	Бусад мөнгөн зарлага	751,915,085.29	1,340,121,642.09
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,651,889,170.06	2,329,768,739.60
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	78,288,133.44	8,993,021.00
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	78,288,133.44	8,993,021.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,540,476,594.30	2,559,965,299.30
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	8,005,688,821.72	2,559,965,299.30
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	2,534,787,772.58	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(10,462,188,460.86)	(2,550,972,278.30)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	21,172,218.10	157,257.43
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	21,172,218.10	157,257.43
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	12,202,995.48	362,767.49
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	12,202,995.48	362,767.49
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	8,969,222.62	(205,510.06)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(5,801,330,068.18)	(221,409,048.76)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,043,794,423.40	242,464,355.22
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	242,464,355.22	21,055,306.46

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,945,269,000.00	420,000,000.00	41,284,046,790.95	2,861,655,327.46	(132,946,546,896.62)	(76,435,575,778.21)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					168,005,060.07	168,005,060.07
Залруулсан үлдэгдэл	11,945,269,000.00	420,000,000.00	41,284,046,790.95	2,861,655,327.46	(132,778,541,836.55)	(76,267,570,718.14)
Өмчит гарсан өөрчлөлт				2,567,116,147.20	0.00	2,567,116,147.20
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					11,255,189,875.54	11,255,189,875.54
Зарласан ногдол ашиг					(5,815,347,850.00)	(5,815,347,850.00)
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,945,269,000.00	420,000,000.00	41,284,046,790.95	5,428,771,474.66	(127,338,699,811.01)	(68,260,612,545.40)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					741,816,184.18	741,816,184.18
Залруулсан үлдэгдэл	11,945,269,000.00	420,000,000.00	41,284,046,790.95	5,428,771,474.66	(126,596,883,626.83)	(67,518,796,361.22)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					19,806,782.13	19,806,782.13
Өмчит гарсан өөрчлөлт		(420,000,000.00)		(5,428,771,474.66)		(5,848,771,474.66)
Зарласан ногдол ашиг					(11,255,189,875.54)	(11,255,189,875.54)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			6,000,668,044.80			6,000,668,044.80
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,945,269,000.00	0.00	47,284,714,835.75	0.00	(137,832,266,720.24)	(78,602,282,884.49)

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2023 он	2024 он			
			Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт						
	Цемент	тн	250,181.0	220,000.0	220,540.8	540.8	1.0
	Шохой	тн	44,860.0	36,000.0	35,307.7	(692.3)	1.0
2	НИЙТ ОРЛОГО	мян.төг	86,268,361.1	74,341,962.6	72,313,251.8	(2,028,710.9)	1.0
	Үйл ажиллагааны орлого:	мян.төг	85,605,128.1	73,111,076.8	70,950,572.0	(2,160,504.8)	1.0
	Үйл ажиллагааны бус орлого:	мян.төг	663,233.0	1,230,885.9	1,362,679.8	131,793.9	1.1
3	НИЙТ ЗАРДАЛ	мян.төг	73,262,280.8	74,337,088.2	72,265,975.6	(2,071,112.5)	1.0
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	9,563,645.6	4,534,497.4	5,062,485.7	527,988.3	1.1
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	13,006,080.3	4,874.5	47,276.1	42,401.7	9.7
5	Цэвэр ашиг	мян.төг	11,255,189.9	4,387.0	19,806.8	15,419.8	4.5
6	Төсөвт төлөх татвар шимтгэл	мян.төг	8,234,335.3	9,400,004.6	8,689,342.5	(710,662.1)	0.9
	ААНОАТ	мян.төг	50,000.0	33,050.9	33,050.9	(0.0)	1.0
	НӨАТ	мян.төг	1,372,760.6	1,731,286.9	1,381,436.9	(349,850.0)	0.8
	НДШ	мян.төг	4,953,792.8	4,746,327.1	4,746,327.1	0.00	1.0
	ХХОАТ	мян.төг	1,136,235.8	1,556,791.8	1,556,791.8	0.00	1.0
	ҮХХТ	мян.төг	520,741.0	642,910.9	642,910.9	0.00	1.0
	Гаалийн татвар	мян.төг	-	-	6,721.1	6,721.1	
	Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	5,205.1	4,979.8	4,979.8	0.00	1.0
	Бусад	мян.төг	195,600.0	684,657.2	317,124.0	(367,533.2)	0.5
	Ногдол ашиг	мян.төг				0.00	
7	Ажиллагсдын тоо	хүн	765.0	752.0	752.0	0.00	1.0
8	Цалингийн сан	мян.төг	25,654,486.2	23,871,289.3	23,462,933.5	(408,355.9)	1.0
9	Ажиллагсдын сарын дундаж цалин	төг	2,794,606.3	2,645,311.3	2,600,059.1	(45,252.2)	1.0
10	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	0.85	1.00	1.00	0.00	1.0
11	Хөрөнгө оруулалт	мян.төг	8,005,688.8	12,064,413.6	8,227,675.4	(3,836,738.2)	0.7
12	Нийт авлага	мян.төг	56,492,920.0	46,533,956.3	59,522,081.2	12,988,124.9	1.3
	Үүнээс: Найдваргүй авлагын хасагдуулга	мян.төг	(36,834,000.6)	(36,834,000.6)	(36,803,223.1)	30,777.5	1.0
13	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	53,126,704.1	107,821,233.8	65,855,527.1	(41,965,706.7)	0.6

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 55,434.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрч, аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Говь экуйпмент ренгал флийт ХХК-аас 3 удаагийн худалдан авалтын чанарын баталгааны 5 хувь болох нийт 55.4 сая төгрөгийг гэрээ дүгнэсэн актад заасан хугацаанд авч үлдэхээр тусгасан боловч барьцааны хугацаа дуусаагүй байхад тус компани руу шилжүүлсэн	1	55,434.5			1	55,434.5						
Дүн	1	55,434.5			1	55,434.5						

3.2 Аудитаар нийт 781,727.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 4 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТ-ны тоо	Тоо	Дүн
Цемент шохой ХХК нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх дотоод аудиторт 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан хөдөлмөрийн гэрээгээр сард 7,000,000.00 /долоон сая/ төгрөгийн цалинг олгохоор тогтоож, нийт 56,744,548.83 /Тавин зургаан сая долоон зуун дөчин дөрвөн мянга таван зуун дөчин найман төгрөг наян гурван мөнгө/ олгосон бөгөөд хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүрэг гүйцэтгэх	1	56,744.5			1	56,744.5						

Цемент шохой ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

байршилд ажиллаагүй, ажлын цагаа бүртгүүлээгүй, алсын зайнаас ажилласан байна.											
Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Л.Наранбаатар нь ажилтнуудыг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсөн тул шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолоор ажил, албан тушаалдаа эргүүлэн томилогдсон тус компанийн 8 ажилтанд 282.6 сая төгрөгийн нөхөн олговор олгосон байна.	1	282,688.9			1	282,688.9					
Тайлант онд үүссэн нийт 6,803.3 сая төгрөгийн авлагаас 74.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	74,720.8			1	74,720.8					
2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд толилуулсан 177.2 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлээгүй, 2016-2022 онуудын хооронд үүсэн 190.4 сая төгрөгийн он дамжсан өглөгийг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	367,573.5			1	367,573.5					
Санхүү хариуцсан захирлын 2015 онд боловсруулж баталсан “Найдваргүй авлагын нөөц байгуулах, бүртгэх болон данснаас хасах журам”-д заасан нөөц байгуулах аргачлалаар авлага нь 4 жилийн дараа найдваргүй авлагад шилжиж байна.	1	-					1	-			
НИЙТ ДҮН	5	781,727.7			4	781,727.7	1	-			

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 20,975.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 20,975.5 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 10,472,975.6 мянган төгрөгийн 302 мэдээлэл, зарлагын 10,502,563.4 мянган төгрөгийн 106 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1		1	20,975,539.0		

